



Дархан-Уул аймаг дахь
Төрийн аудитын газар

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ТӨСВИЙН ТОДОТГОЛООР 44
ТАХ-Г ШИНЭЭР НЭМЖ БАТАЛСАН, ЗАХИАЛАГЧААС СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛЫГ ХУГАЦАА АЛДАЖ
ХҮРГҮҮЛСНЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ 57.8
ХУВЬТАЙ ГАРСАН БАЙНА





БҮЛЭГ 1. ШИНЭЭР ТӨЛӨВЛӨСӨН 21 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛААГҮЙ БАЙНА

Тайлант онд ИТХ-ын 2024 оны 07 дугаар тогтоол, 09 дүгээр тогтоолоор тус тус тодотгол хийж, ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулснаар нийт 14,800.1 сая төгрөгийн 50 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13,177.1 сая
төгрөгийн 80 төсөл, арга хэмжээ

Их засварын зардал 4,081.4 сая төгрөгийн 39 төсөл,
арга хэмжээ



Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд
437 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 3,287.4 сая
төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ



**Дүгнэлт: Шинээр төлөвлөсөн 21 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг
магадлалаар баталгаажуулаагүй байна**

Тайлант хугацаанд нийт 45,361.9 сая төгрөгийн 230 төсөл, арга хэмжээг баталж, шинээр
эхлэх 20,982.9 сая төгрөгийн 146 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.



Нээлттэй тендер шалгаруулалт 13,452.6 сая төгрөгийн 29 төсөл, арга
хэмжээ

Харьцуулалтын аргаар 1,347.5 сая төгрөгийн 21
төсөл, арга хэмжээ





БҮЛЭГ 2. ЗАХИАЛАГЧААС ТАХ-НИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ МАТЕРИАЛЫГ ХУГАЦАА АЛДАЖ ХҮРГҮҮЛСНЭЭС ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХОЙШИЛСОН БАЙНА

Нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар нийт 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй, 3 худалдан авах ажиллагаа зарлаагүй зэрэг нь 11 дүгээр сард хийсэн төсвийн тодотголоор шинэ төсөл, арга хэмжээ төлөвлөсөн, захиалагчаас сонгон шалгаруулалтын баримт материалыг хугацаа алдаж хүргүүлснээс шалтгаалж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хойшилж төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтэд сөргөөр нөлөөж байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас оролцогч ирээгүй болон шаардлага хангасан тендер ирүүлээгүй шалтгааныг судалж, дахин тендер шалгаруулалт зарлахдаа өгөгдлийн хүснэгт дэх шалгуур үзүүлэлтийг бууруулсан нь зарим төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлсэн байна



Дүгнэлт: Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг хууль журамд нийцүүлэн боловсруулжээ.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 230 төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтэд 21,221.0 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 7,433.1 сая төгрөгийн санхүүжүүлсэн байна.



Тайлант онд 134 төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтэд 26.5-79.3 хувийг олгожээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 230 төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн дуусахаар төлөвлөсөн боловч 31.7 хувь буюу 73 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 26.1 хувь буюу 60 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.



Мөн хөрөнгө оруулалтаар “Иргэдийн оролцоотой төсөл, хөтөлбөр”-т зарцуулахаар 600.0 сая төгрөг төлөвлөснөөс ижил төстэй ажлуудыг багцлалгүй тендер шалгаруулалт зарлахаас зайлсхийсэн 349.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээ байна.

Чанарын баталгаат хугацаа дуусаагүй 4 ТАХ-ний ашиглалтын явцад гарсан зөрчлийг гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга болон “ДХББЗГ” ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.





БҮЛЭГ 3. БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙН 15 ХУВИЙГ АШИГЛААГҮЙ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 57.8 ХУВЬТАЙ БАЙГАА ЗЭРЭГ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН БУУРАХАД НӨЛӨӨЛЖ БАЙНА



Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс 1,166.1 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээний жагсаалт, баримт материалыг аймгийн ОНӨГ-т хүргүүлээгүйгээс бүртгэлд тусгаагүй.



Дүгнэлт: Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнээс 1,166.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 666.3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтад оруулаагүй байна

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✓ ТАХ-г Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлого хөтөлбөрт уялдуулж төлөвлөсөн боловч зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүй 9,116.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 21 барилга байгууламжийг төлөвлөж батлуулсан байна
- ✓ Захиалагчаас ТАХ-ны сонгон шалгаруулалтын баримт материалыг хугацаа алдаж хүргүүлснээс худалдан авах ажиллагаа хойшилж, төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна
- ✓ Аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор нэмж баталсан 6,422.5 сая төгрөгийн 44 ТАХ огт хэрэгжээгүй байна
- ✓ ТАХ-ний хэрэгжилт 57.8 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байгаагаас гадна хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнээс 1,166.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 666.3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтад оруулаагүй байна
- ✓ Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөрт 27 ТАХ-г 600.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс тоног төхөөрөмж нийлүүлэхэд 245.3 сая төгрөг, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 53.6 сая төгрөг, авто замын зогсоол, явган замын ажилд 51.0 сая төгрөг, өсвөрийн тамирчид төсөлд 33.3 сая төгрөг олгож, ижил төстэй ажлуудыг багцлалгүй, тендер шалгаруулалт зохион байгуулахаас зайлсхийсэн байна
- ✓ “ДХББЗГ” ОНӨААТҮГ-ын ашиглалтын хугацаанд тавих хяналт хангалтгүй байна



ТӨСВИЙН ТОДОТГОЛООР 44 ТАХ-Г ШИНЭЭР НЭМЖ БАТАЛСАН, ЗАХИАЛАГЧААС СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛЫГ ХУГАЦАА АЛДАЖ ХҮРГҮҮЛСНЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ 57.8 ХУВЬТАЙ ГАРСАН БАЙНА

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ШИЙДВЭРЛЭЛТ:



Албан шаардлага:

Чанарын баталгаат хугацаа дуусаагүй 4 ТАХ-ний ашиглалтын явцад гарсан зөрчлийг гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад 1, “ДХББЗГ” ОНӨААТҮГ-т 3 хүргүүлсэн.

Зөвлөмж:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын даргад 1, аймгийн Засаг даргад 3, “Дархан хот байгуулалт барилга, захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т 1, Орон нутгийн өмчийн газарт 1, нийт 6 зөвлөмж өгч ажиллаа.

